

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ИЛЧИТ ХУТАГ” ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: БУА/2020/05-ГА

Анхан шатны баримтын бүрдэлт,
авлагын тооцоолол дутуу
дотоод хяналтыг сайжруулж
ажиллах шаардлагатай байна.

БУЛГАН АЙМАГ 2020 ОН

Булган аймаг дахь Төрийн аудитын газрын
Дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр

Утас: 70342580	Цахим хаяг: Ankhbayard@audit.gov.mn
Аудитын менежер Ж.Энхцоодол	
Утас: 70342716	Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn
Ахлах аудитор П.Мөнхтуяа	
Утас: 70342716	Цахим хаяг: MonkhtuyaP@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой
мэдээллийг дараах хаягаар авна уу.
Цахим хуудас www.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар

Хүснэгтийн товъёг

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

БҮЛЭГ А. “Илчит хутаг” ОНӨААТҮГ-ын төлөвлөлт үр нөлөөтэй байна.

.....7

А.1. “Илчит хутаг” ОНӨААТҮГ нь тухайн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн төлөвлөгөөг төлөвлөж ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэж батлуулан ажиллажээ......7

А.1.1 “Илчит хутаг” ОНӨААТҮГ нь 2019 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн төлөвлөгөөг төлөвлөн ажилласан байна.....7

А.1.2 Байгууллагын зорилго, зорилтын түвшинд хүрч ажилласан байна.....7

А.1.3 Сумын ИТХ-аар “Илчит хутаг” ОНӨААТҮГ-ын дүрмийг батлуулан ажиллажээ.....7

А.1.4 Бүтэц орон тоог оновчтой батлуулан ажиллажээ.....7

А.2 Орлогын бүрдүүлэлт, ХАА-ны төлөвлөлт үр нөлөөтэй байна......8

А.2.1 “Илчит хутаг” ОНӨААТҮГ-ын орлогын бүрдүүлэлт, ашгийн тооцоог үр дүнтэй төлөвлөж, орлогын төлөвлөгөөг 94 хувиар биелүүлсэн байна.....9

А.2.2 Хөрөнгийн худалдан авах төлөвлөгөөг 8240.0 мянган төгрөгөөр батлуулж 2115.1 мянган төгрөгөөр илүү зарцуулалт хийгдсэн байна.....9

Б. “Илчит хутаг” ОНӨААТҮГ-ын санхүүгийн төлөвлөгөөний зарцуулалт үр дүнтэй зарцуулагдаж жилийн эцэст 6957.0 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна......9

Б.1 Санхүүгийн төлөвлөгөө үр дүнтэй хэрэгжсэн ч анхан шатны баримтын бүрдэлт дутуу, авлагыг дутуу бүртгэж тайлагнасан, олон жил болсон авлагыг барагдуулж ажиллаагүй зөрчлүүд илэрлээ.....9

Б.1.1 Жилийн орлого, зарлагыг оновчтой төлөвлөж батлуулсан байна.....9

Б.1.2 Санхүүгийн төлөвлөгөөний дагуу зарцуулалт хийгдсэн ч 26219.6 мянган төгрөгийн анхан шатны баримтын бүрдэлт дутуу зөрчил илэрлээ.....9

Б.1.3 Жилийн эцсийн санхүүгийн мэдээ, тайланг үнэн зөв мэдээлж ажиллажээ.....9

Б.1.4 Авлага өглөгийг үнэн зөв тайлагнаагүй, дутуу, ажилчидтай жилийн эцэст тооцоо нийлж ажиллаагүйгээс 3470.0 мянган төгрөгийн авлагыг тайлан бүртгэлд тусгаагүй байна.....9-10

Б.1.5 Шинээр бэлтгэсэн бараа материалыг тайлан бүртгэлд бүрэн тусгаж тайлагнасан ч анхан шатны баримтын бүрдэлт дутуу зөрчил илэрлээ.....10

Б.2 ХАА-г хууль журмын дагуу гэрээ байгуулж ажиллажээ......10

Б.2.1 Бэлтгэн нийлүүлэгч болон гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж ажилласан байна.....10

Б.2.2 Гүйцэтгэгч тухайн ажлыг гэрээний дагуу хугацаандаа чанартай гүйцэтгэжээ.....10-11

Б.2.3 Гүйцэтгэгч компани руу 1139.6 тн нүүрсний үнэ 33048.4 мянган төгрөг, тээвэрлэлтийн 88085.8 мянган төгрөгийг тус тус шилжүүлэн ажиллажээ.....11

Б.3 Дотоод хяналтыг бүрэн хэрэгжүүлж үр дүнг дүгнүүлэн тооцож ажиллажээ......11

Б.3.1 ТУЗ-ын гишүүдийг сонгож ажилласан боловч сүүлийн 2 жил сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолыг үндэслэн үйл ажиллагааг явуулсан байна.....11

Б.3.2 Байгууллагын үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сумын ИТХ болон төрийн сангаас дотоод хяналт хийж ажиллажээ.....	11
Б.3.3 Байгууллагын жилийн үйл ажиллагааны тайланг тайлагнаж, үр дүнг тооцож ажиллаж хангалтай гэж дүгнүүлсэн байна.....	11
ДҮГНЭЛТ.....	12
ЗӨВЛӨМЖ.....	12
МЭДЭГДЭЛ.....	12

Товчилсон үгийн тайлбар

ТТХ	Төсвийн тухай хууль
ИТХТ	Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоол
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ААНҮАТЗТХ	Аж ахуй нэгжийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль
КТХ	Компаний тухай хууль
ХХК	Хариуцлагатай хувьцаат компани

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл	8
Хүснэгт 2		
Хүснэгт 3		

Зургийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1	Авлагын насжилтын үзүүлэлт	10
Зураг 2		
Зураг 3		

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл
Аудитын зорилт	Аймаг дахь Төрийн аудитын газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд “ОНӨААТҮГ-ын 2019 оны үйл ажиллагааны хэрэгжилт үр дүн”-д гүйцэтгэлийн аудит хийлээ. Аймгийн ОНӨААТҮГ-ын 2019 оны үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж дүгнэлт гарган зөвлөмж бловсруулж дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ. Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: - ОНӨААТҮГ-ын ажлын төлөвлөлт үр нөлөөтэй байгаа эсэх. - ОНӨААТҮГ-ын санхүүгийн төлөвлөгөөний зарцуулалт үр дүнтэй зарцуулагдсан эсэх.
Аудитын хамарсан хүрээ	Аудитад аймгийн ОНӨААТҮГ-уудын үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий бусад байгууллага, аймаг сумын Засаг дарга, түүний харьяа байгууллага, гүйцэтгэгч нарын холбогдох үйл ажиллагааг хамруулна.
Аудитын хязгаарлалт	
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхэд Гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100), Монгол Улсын Төрийн аудитын стандарт, Гүйцэтгэлийн аудитын журмыг ашиглах бөгөөд шалгагдагч байгууллагын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа болон судалгаа авах, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, захиалагч гүйцэтгэгч байгууллагын гүйцэтгэл, хяналт, санхүүжилтийн тайлан, бусад шаардлагатай баримт материалд дүн шинжилгээ хийх горимыг хэрэгжүүлэх, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж аудитын дүгнэлт, зөвлөмжийг боловсрууллаа. Аудитыг Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр хянан удирдаж, аудитын менежер Ж.Энхцоодол аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор П.Мөнхтуяа хийж гүйцэтгэлээ.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитын удирдамжийн дагуу гүйцэтгэлийн аудитыг 2020 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс 2020 оны 06 дугаар сарын 15-ны өдөр хүртэл ажлын 10 хоногт хийж аудитыг үе шатны хяналтаар хянуулж аудитын тайлан, нотлох баримтыг бэлтгэн ажиллалаа.
Хүндрэл бэрхшээл	

А. “Илчит хутаг” ОНӨААТҮГ-ын төлөвлөлт үр нөлөөтэй байна.

А.1 “Илчит хутаг” ОНӨААТҮГ нь тухайн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн төлөвлөгөөг төлөвлөж ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэж батлуулан ажиллажээ.

А.1.1 “Илчит хутаг” ОНӨААТҮГ нь 2019 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн төлөвлөгөөг төлөвлөн ажилласан байна.

“Илчит Хутаг” ОНӨААТҮГ нь ТУЗ-ын дарга, гишүүдийн оролцоогүйгээр сүүлийн 2 жил ажиллаж өөрийн үйл ажиллагааны төсөв, орон тоо, худалдан авах төлөвлөгөө зэргийг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулж жил бүр төсвөө хэлэлцэн батлуулж иржээ.

Тус байгууллага нь 2019 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 10 тоот тогтоолоор 2019 оны төсөв, төлөвлөгөөг сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн тогтоолоор орлого, зардал, үр ашгийн төсвийг боловсруулан батлуулж тус тогтоолоор тухайн жилд 34 орон тоогоор үйл ажиллагааг явуулах, ажилчдын цалингийн санг 175696.6 мянган төгрөгөөр, нийт жилийн орлогыг 577028.1, зарлагыг 544449.3, цэвэр ашгийг 2267.4 мянган төгрөгөөр тус тус төлөвлөн тооцоолж үйл ажиллагаа, санхүү, худалдан авалтын төлөвлөгөөг батлуулжээ.

А.1.2 Байгууллагын зорилго, зорилтын түвшинд хүрч ажилласан байна.

“Илчит хутаг” ОНӨААТҮГ нь өөрийн байгууллагын эрхэм зорилгын хүрээнд 2019 онд үйл ажиллагаагаа үндсэн чиглэл, дэд чиглэл болгон хувааж нийт 9 чиглэлээр үйл ажиллагааг явуулахаар зорилго тавин ажилласан байна.

Үндсэн үйл ажиллагааны чиглэлүүдээс төвлөрсөн дулааны шугам сүлжээгээр тасралтгүй дулаанаар хангаж шинээр 4 аж ахуй нэгжийн барилгын дулааны шугамыг холбож, усан сангийн шинжилгээ ариутгал халдваргүйжүүлэх ажлыг цаг хугацаанд нь хийлгэж гадна гэрэлтүүлэг, ногоон байгууламж камержуулалт, хашаа, авто худгийн талбайг сайжруулах ажлуудыг хийсэн, сумын төвийн айл өрхүүдийн, аж ахуй нэгж, төсөвт байгууллагуудын хог хаягдлыг захиалгын дагуу сар тутам тогтмол ачиж, сумын төвийн гэрэлтүүлгийн засварын ажлуудыг хийсэн нь өөрийн байгууллагын зорилтот түвшний ажлуудыг хийсэн ч сумын төвийн орчин, тохижилт үйлчилгээнд хувь нэмэр оруулснаар үр дүн нь илэрч байна.

Мөн санхүүжилтийн гол эх үүсвэр болох дулаан үйлдвэрлэлийн орлогын гэрээг 17 аж ахуй нэгж байгууллага, айл өрх, иргэдтэй хийхдээ 2016 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 08 тоот тушаалын дагуу халаалтын эхлэх хугацааг тухайн оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөр, халаалт дуусах хугацааг дараа оны 05 дугаар сарын 15-ны өдрөөр дулааны гэрээг нийт төсөвт байгууллага, аж ахуй нэгж өрх айлуудтай хийж ажиллажээ.

А.1.3 Сумын ИТХ-аар “Илчит хутаг” ОНӨААТҮГ-ын дүрмийг батлуулан ажиллажээ.

“Илчит хутаг” ОНӨААТҮГ нь байгууллагын дүрмийг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 18 дугаар тогтоолын хавсралтаар 12 бүлэг 91 заалттайгаар боловсруулан батлуулсан байна.

Дээрх дүрмийг одоо хүртэл мөрдөж байгаа ч ТУЗ-ын дарга, гишүүдийг оролцуулахгүй, сумын ИТХ-ын Тэргүүлэгчдэд ажлаа тайлагнан үйл ажиллагааг явуулж байгаа нь цаашид байгууллагын дүрмийг шинэчлэн боловсруулах шаардлагатай гэж үзэж байна.

А.1.4 Бүтэц орон тоог оновчтой батлуулан ажиллажээ.

“Илчит хутаг” ОНӨААТҮГ нь 2019 оны байдлаар 34 орон тоотойгоор үйл ажиллагааг явуулахаар төлөвлөн батлуулсан ч 2 зөвлөх инженерийн орон тоог нэмж батлуулж 2019 оны 09 дүгээр сараас 26 ажилтны бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж орон тооны цомхотголоор 3, сахилгын зөрчлөөр 1, өөрийн санаачилгаар 3 нийт 7 хүн ажлаас чөлөөлөгдөж ЖА-ны амралттай хүний оронд 2 авч ажилласан үзүүлэлтэй байна.

А.2 Орлогын бүрдүүлэлт, ХАА-ны төлөвлөлт үр нөлөөтэй байна.

А.2.1 “Илчит хутаг” ОНӨААТҮГ-ын орлогын бүрдүүлэлт, ашгийн тооцоог үр дүнтэй төлөвлөж, орлогын төлөвлөгөөг 94 хувиар биелүүлсэн байна.

Орлогын төлөвлөлтөөс дурдвал: дулаан үйлдвэрлэлийн орлогоос 17 ах ахуй нэгж байгууллагаас 488769.1, цэвэр бохир усны орлогоос 7530.0, дулаан шугам сүлжээнд шинээр дотор шугам сүлжээний угсралт хийх ажлын хөлсний орлогоос 10550.0, халуун ус, хог тээврийн орлогоос 11040.0, туслах үйл ажиллагааны орлогоос 32130.0, хөрөнгө борлуулах орлогоос 27009.0 мянган төгрөг оруулахаар нийт 577028.1 мянган төгрөгийн орлогын төлөвлөгөөг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр үзэхэд 2019 онд нийт 551804.1 мянган төгрөгийн орлого, 521332.6 мянган төгрөгийн зардал гарч зарцуулснаар мөнгөн гүйлгээний тайлангаар тайлагнасан боловч орлого үр дүнгийн тайлангаар 6957.0 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажилласнаар тайлагнажээ.

Орлогын төлөвлөгөөг гүйцэтгэлээр харуулбал:

/мян/төг/

№	Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Тайлбар
1	Дулаан үйлдвэрлэлийн орлого	488769.1	491072.4	2303.3	
2	Халуун ус, худаг, хог тээврийн үйлчилгээний орлого	11040.0	11828.2	788.2	
3	Цэвэр ус, бохир ус татан ариутгах үйлчилгээний орлого	7530.0	7787.2	257.2	
4	Дулааны шугам сүлжээнд шинээр холболт хийх, дотор шугам сүлжээний угсралт хийх ажлын хөлсний орлого	10550.0	977.0	-9573.0	Зуухны хүчин чадал бага учраас төлөвлөсөн ажлууд хийдгээгүй байна асуудлаас
5	2018 оны туслах үйл ажиллагааны үлдэгдэл бүтээгдэхүүн борлуулалт	32130.0	32130.0	0	
6	Хөрөнгө борлуулах орлого	27009.0	0	-27009.0	
Нийт дүн		577028.1	543794.8	33233.3	

Төлөвлөсөн орлогын төлөвлөгөөг гүйцэтгэлтэй харьцуулахад 94 хувийн орлогын биелэлтэй ажиллажээ.

А.2.2 Хөрөнгийн худалдан авах төлөвлөгөөг 8240.0 мянган төгрөгөөр батлуулж 2115.1 мянган төгрөгөөр илүү зарцуулалт хийгдсэн байна.

Худалдан авах төлөвлөгөөг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн 10 тоот тогтоолын хавсралтаар 8240.0 мянган төгрөгийн 14 төрлийн сэлбэг худалдан авахаар, хөрөнгө борлуулах орлогыг 27009.0 мянган төгрөгөөр тус тус төлөвлөж батлуулсан байна.

Тус газрын худалдан авах төлөвлөгөө болон худалдан борлуулах орлогын төлөвлөгөөг гүйцэтгэлтэй харьцуулахад түүвэрлэлтээр 10355.1 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл худалдан авч батлагдсан төлөвлөгөөнөөс 2115.1 мянган төгрөгөөр илүү сэлбэгийн зардал зарцуулсан нь цаашид гарах эрсдэлийг зөв тооцоолж төсвийг батлуулж ажиллах шаардлагатай гэж үзэж байна.

Б. “Илчит хутаг” ОНӨААТҮГ-ын санхүүгийн төлөвлөгөөний зарцуулалт үр дүнтэй зарцуулагдаж жилийн эцэст 6957.0 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажиллажээ.

Б.1 Санхүүгийн төлөвлөгөө үр дүнтэй хэрэгжсэн ч анхан шатны баримтын бүрдэлт дутуу, авлагыг дутуу бүртгэж тайлагнасан, олон жил болсон авлагыг барагдуулж ажиллаагүй зөрчлүүд илэрлээ.

Б.1.1 Жилийн орлого, зарлагыг оновчтой төлөвлөж батлуулсан байна.

“Илчит хутаг” ОНӨААТҮГ нь 2019 оны жилийн орлого, зарлагын төлөвлөгөөг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн 10 тоот тогтоолын нэгдүгээр хавсралтаар байгууллагын 2019 оны орлогыг 546968.7, зардлыг 544449.3, цэвэр ашгийг 2267.4 мянган төгрөгөөр тус тус төлөвлөж орлого, зардал тус бүрээр нь сар сараар задалж төлөвлөлтийг хийж батлуулсан нь сарын борлуулалтын орлого, зардлыг хянаж ажиллахад үр дүнтэй ажиллахаар харагдаж байна.

Жилийн эцэст орлого үр дүнгийн тайлангаар үзэхэд борлуулалтын 498492.1 мянган төгрөгийн орлого орж 491535.1 мянган төгрөгийг зарцуулалт хийгдэж 6957.0 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажилласан гэж тайлагнажээ.

Б.1.2 Санхүүгийн төлөвлөгөөний дагуу зарцуулалт хийгдсэн ч 26219.6 мянган төгрөгийн анхан шатны баримтын бүрдэлт дутуу зөрчил илэрлээ.

“Илчит хутаг” ОНӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлангаар 521332.6 мянган төгрөгийн зарцуулалт хийгдэж оны эцэст байгууллагын харилцах дансанд 16035.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэйгээр тайлагнажээ.

Тус газрын зардлыг түүвэрлэн үзэхэд анхан шатны баримтын бүрдэлт дутуу, томилолтын хуудсыг очсон газраар тамга, тэмдэг дарж баталгаажуулаагүй, он сар өдөр тавигдаагүй, гарын үсэггүй, удирдамж, сургалт зөвлөгөөний хөтөлбөр байхгүй, жолоочийн тооцооны замын хуудас хөтлөөгүй, бөглөгдөөгүй буудлын баримт хавсаргасан, анхан шатны баримтын бүрдэлт дутуу зэрэг зөрчлүүд илэрлээ.

Тухайлбал: Байгууллагын дарга 25342.6 мянган төгрөгийн шатахуун зарцуулах цохолт хийсэн боловч жолоочийн тооцооны замын хуудас хөтлөөгүй зөрчилд, 1701.0 мянган төгрөгийг томилолтын зардалд зарцуулснаас 824.0 мянган төгрөгийн зарцуулалтын томилолтын хуудсыг дутуу бөглүүлсэн, анхан шатны баримтын бүрдэлт дутуу, 877.0 мянган төгрөгийн томилолтын хуудас бөглөгдөөгүй, анхан шатны баримт дутуу, нийт 26219.6 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага бичлээ.

Цаашид зардлын гүйлгээ хийхдээ анхан шатны баримтын бүрдлийг үнэн зөв бүрдүүлж НББ-ийн тухай хуулийг мөрдлөг болгон батлагдсан маягтын дагуу жолоочийн тооцооны замын хуудсыг бөглөж ажиллах шаардлагатай байна.

Б.1.3 Жилийн эцсийн санхүүгийн тайлан, мэдээг үнэн зөв мэдээлж ажиллажээ.

“Илчит хутаг” ОНӨААТҮГ нь 2019 онд жилийн эцсийн байдлаар эргэлтийн хөрөнгийн үлдэгдлийг 110323.5, эргэлтийн бус хөрөнгийн үлэгдлийг 4228158.8 мянган төгрөгөөр буюу нийт хөрөнгийн дүнг 4338482.3 мянган төгрөгөөр тайлагнаж хагас, бүтэн жилээр хуулийн хугацаанд санхүүгийн тайланг мэдээлж баталгаажуулан ажилласан байна.


Байгууллагын эд хөрөнгийн тооллогыг байгууллагын захирлын 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/8 тоот тушаалаар эд хөрөнгийн тооллогын комисс томилох тухай тушаал гарган жилийн эцэст эд хөрөнгийн тооллого хийж ажиллажээ.

Б.1.4 Авлага өглөгийг үнэн зөв тайлагнаагүй, дутуу, ажилчидтай жилийн эцэст тооцоо нийлж ажиллаагүйгээс 3470.0 мянган төгрөгийн авлагыг тайлан бүртгэлд тусгаагүй байна.

Тус байгууллага нь 2019 онд авлагыг 2114.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 8943.5 мянган төгрөгийн өглөгийг 5375.7 мянган төгрөгөөр бууруулж жилийн эцэст 3567.8 мянган төгрөгийн өглөгтэй, 28720.2 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй тайлагнажээ.

Авлага, өглөгийн насжилтыг гарахад авлагын 45 хувь нь 2015-2017 оны хооронд үүссэн авлагууд байна.

Үүнийг графикаар харуулбал:



Графикаас харахад 2015, 2017, 2018 онд үүссэн нийт 17591.2 мянган төгрөгийн авлагуудаас 54 хувийг 2015 оны авлага эзэлж байна.

Тус байгууллага нь дээрх авлагуудыг барагдуулах талаар холбогдох байгууллага иргэдээс шаардсан боловч анхан шатны баримт дутуу, тухайн үед ажиллаж байсан дарга, нягтлан бодогч болон холбогдох хүмүүс ажлаас чөлөөлөгдсөн шалтгаанаар барагдахгүй удаж байгаа гэсэн тайлбарыг өгч байна.

Байгууллагын ажилчдаас авах авлагыг түүвэрлэн үзэхэд ажилчидтай тооцоо нийлж ажилладаггүй, үүнээс үүдээд 2019 онд шинээр үүссэн 3470.0 мянган төгрөгийн ажилчдад олгосон цалингийн урьдчилгааг жилийн эцэст суутган тооцоогүй, авлагын тайланд тусгаагүй зөрчил илэрсэнд төлбөрийн акт бичлээ.

Цаашид авлага нэмэгдүүлж ажиллахгүй, авлага барагдуулж ажиллах тал дээр ажил зохион байгуулж ажиллах шаардлагатай байна.

Б.1.5 Шинээр бэлтгэсэн бараа материалыг тайлан бүртгэлд бүрэн тусгаж ажилласан ч анхан шатны баримтын бүрдэлт дутуу зөрчил илэрлээ.

Тухайн онд тус газар нь үндсэн хөрөнгийн худалдан авалт хийгээгүй, 129224.3 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалт хийгдэж холбогдох тайлан бүртгэлд бүрэн тусгаж ажилласан ч 11834.9 мянган төгрөгийн зарлагын баримт болон ө баримтыг өөр хүний зарлагын баримтаар хавсаргасан зөрчил илэрсэн нь НББ-ийн тухай хуулийн 13.6¹, 13.7², гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй тул зөвлөмж хүргүүлэн ажиллалаа.

Б.2 ХАА-г хууль журмын дагуу нүүрсний бэлтгэн нийлүүлэгчтэй гэрээ байгуулж ажилласан байна.

Б.2.1 Бэлтгэн нийлүүлэгч болон гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж ажилласан байна.

“Илчит хутаг” ОНӨААТҮГ нь 2019 онд “Баян-тээг” ХХК-тай нүүрс нийлүүлэх, “Дэл агт” ХХК-тай тээвэрлэлтийн гэрээг тус тус байгуулан ажиллажээ.

Нүүрс нийлүүлэх гэрээг 1тн нүүрсийг 29.0 мянган төгрөгөөр 1000 тн нүүрс нийлүүлэхээр, 1тн нүүрс тээвэрлэлтийн гэрээг 80.0 мянган төгрөгөөр тооцоолон тус бүр гэрээ байгуулсан байна.

Б.2.2 Гүйцэтгэгч тухайн ажлыг гэрээний дагуу хугацаандаа чанартай гүйцэтгэжээ.

Тухайн жилд “Баян-тээг” ХХК-иас нүүрс нийлүүлэх тээвэрлэлтийн гэрээг 2019 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 05 дугаар сарын 20-ны өдөр хүртэл, тээвэрлэлтийн гэрээг “Дэл агт” ХХК-тай 2019 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 2020

¹ Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна,

² Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.

оны 05 дугаар сарын 20-ны өдөр хүртэл нүүрс бэлтгэх хугацаагаар гэрээг хийж гэрээний хугацаанд бэлтгэн нийлүүлэгчид нүүрсийг бэлтгэн нийлүүлсэн байна.

Б.2.3 Гүйцэтгэгч компани руу 1139.6 тн нүүрсний үнэ 33048.4 мянган төгрөг, тээвэрлэлтийн 88085.8 мянган төгрөгийг тус тус шилжүүлэн ажиллажээ.

“Баян-тээг” ХХК-тай 1000 тн нүүрс бэлтгэн нийлүүлж авахаар гэрээ байгуулсан, гүйцэтгэлээр 1139.6 тн буюу нүүрсний үнэ 33048.4 мянган төгрөгийг шилжүүлж гэрээ хийснээс 4048.4 мянган төгрөгийн 139.6 тн нүүрс илүү нийлүүлж худалдан авсан байна.

“Дэл-агт” ХХК-тай нүүрс тээвэрлэлтийн гэрээний хөлсөнд 88085.8 мянган төгрөгийг шилжүүлж ажилласныг нүүрсний үнэтэй харьцуулахад жилийн хэрэглэсэн нүүрсний үнийг тээвэрлэлтийн хөлсөнд өгсөн нь нүүрс тээвэрлэх газар хол байдгаас үүдээд шатахуун тээвэрлэлтийн зардал өндөр гарсан нь харагдаж байна.

Б.3 Дотоод хяналтыг бүрэн хэрэгжүүлж үр дүнг дүгнүүлэн тооцож ажиллажээ.

Б.3.1 ТУЗ-ын гишүүдийг сонгож ажилласан боловч сүүлийн 2 жил сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн тогтоолыг үндэслэн үйл ажиллагааг явуулсан байна.

“Илчит хутаг” ОНӨААТҮГ-ын ТУЗ-ын дарга, гишүүдийн ажиллах хугацаа 2016 онд дуусгавар болсноор сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 52 тоот тогтоолоор 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн томилж тогтоосон байна.

Сүүлийн 2 жил ТУЗ-ын дарга болон гишүүд ажлаа бүрэн хэрэгжүүлж ажиллахгүй удаашралтай байсан учир сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн шийдвэрээр байгууллагын үйл ажиллагаа, санхүүгийн төлөвлөгөөний дагуу зохион байгуулан ажилласан байна.

Б.3.2 Байгууллагын үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сумын ИТХ болон төрийн сангаас дотоод хяналт хийж ажиллажээ.

“Илчит хутаг” ОНӨААТҮГ нь 2019 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/02 тоот тушаалаар үйлчлүүлэгчийн талоны бүртгэлд тулгалт хийх, цэвэрлэгээ, ариутгалыг шалгах, ажлын цаг баримтлах, орлого тушаалт зэрэгт дотоод хяналт хийхээр дотоод хяналтын ажилтанд үүрэг болгон ажилласан байна.

Мөн сумын ИТХ болон төрийн сангаас дотоод хяналтыг 2 удаа хийж санхүүгийн баримт материалын бүрдэлт, шилэн дансны хэрэгжилт тайлан бүртгэлтэй холбоотой зөвлөмж зөвлөгөө өгч ажилласан боловч дотоод хяналтын тайлан мэдээг баталгаажуулж өгөөгүй амаар өгч ажиллажээ.

Цаашид дотоод хяналт шалгалтын тайлан мэдээ, ажилласан тухай тэмдэглэл зэргийг баримтжуулах, ИТХ-аас өгсөн үүрэг даалгавар, зөвлөмжийн хэрэгжилтийг гаргуулан авч ажиллах шаардлагатай байна.

Б.3.3 Байгууллагын жилийн үйл ажиллагааны тайланг тайлагнаж, үр дүнг тооцож хангалтай гэсэн дүгнэлтээр дүгнүүлсэн байна.

Тус байгууллага нь байгууллагын дүрэмд заасны дагуу сумын ИТХ-ын ээлжит 8 дугаар хуралдаанд 2019 оны жилийн үйл ажиллагааны тайланг танилцуулж хангалттай гэж дүгнүүлжээ.

Жилийн үйл ажиллагааны дүгнэлтээс харахад төлөвлөсөн ашгаас 4692.3 мянган төгрөгөөр илүү цэвэр ашигтай ажиллаж сум орон нутаг иргэдийг дулаан үйлдвэрлэл, халуун ус, хог цэвэрлэгээ, цэвэр ус, засвар үйлчилгээг иргэд байгууллагуудад түргэн шуурхай үйлчилгээгээр ханган ажилласан нь байгууллагын зорилго зорилтоо бүрэн хангалттай хэрэгжүүлж байгаа нь үр дүнд хүрч ажилласан нь, мөн сум орон нутгийн захиргаа дэмжлэг тусалцаа үзүүлэн хамтран ажилласнаар тодорхой үр дүнд хүрсэн нь илэрхийлэгдэж байна.

Аудитаар нийт 47052.1 мянган төгрөгийн төлбөр зөрчил илрүүлснээс 3470.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 26219.6 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 17362.5 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлэн ажиллалаа.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

- Тухайн байгууллага нь жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг сумын ИТХ-ын тэргүүлэгчдэд танилцуулан батлуулж ажилласан байна.
- Жилийн үйл ажиллагааны орлого, зарлага, ашгийн тооцоог 2267.4 мянган төгрөгийн ашигтай ажиллана гэж тооцоолсноос 4689.6 мянган төгрөгөөр илүү цэвэр ашигтай ажиллажээ.
- Орлого бүрдүүлэхээр төлөвлөсөн 5 ажлаас 4 ажил нь бүрэн хийгдэж төлөвлөсөн орлогын 94 хувийг бүрдүүлж ажилласан байна.
- Ажилчидтай хагас бүтэн жилээр тооцоо нийлж ажиллаагүй, 3470.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгааг суутган тооцоогүй, авлагын тайланд тусгаж тайлагнаагүй, олон жил босон авлагыг барагдуулж ажиллаагүй.
- Анхан шатны баримтын бүрдэлт дутуу, е баримт болон зарлагын баримт зөрүүтэй хавсаргасан, НББ-ийн тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй.
- Томилолтын зардлыг удирдамж, хөтөлбөргүй зарцуулсан, мөн очсон газраар тамга, тэмдэг, гарын үсэг зуруулж баталгаажуулаагүй.
- Жилийн үйл ажиллагааны тайланг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулж хангалтай гэж дүгнэжээ.
- Дотоод хяналтыг сумын ИТХ болон төрийн сангаас хийсэн боловч баримтжуулж ажиллаагүй амаар зөвлөгөө зөвлөмж өгч ажилласан байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

Нэг: Сумын ИТХ-ын дарга Н.Бат-Эрдэнэд:

1. “Илчит хутаг” ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаанд хийх дотоод хяналтын ажлыг хагас бүтэн жилээр зохион байгуулан явуулж хэвших.
2. Дотоод хяналтаар өгсөн үүрэг даалгавар, зөвлөмжийн хэрэгжилтийг тооцон ажиллаж байх.

Хоёр. “Илчит хутаг” ОНӨААТҮГ-ын гүйцэтгэх захирал О.Далайцэрэн, нягтлан бодогч Ж.Мөнхбаяр нарт:

1. Харилцагч байгууллага, аж ахуй нэгж, иргэд болон ажилчидтай хагас бүтэн жилээр тооцоо нийлж ажиллан баримтжуулж байх.
2. Олон жил болсон авлагыг барагдуулах тал дээр ажил зохион байгуулж ажиллах
3. Анхан шатны баримтын бүрдлийг хууль, журмын дагуу бүрдүүлэн ажиллаж дотоод хяналтыг сайжруулах.

МЭДЭГДЭЛ:

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажил зохион байгуулж хэрэгжилт, үр дүнг 2020 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор хариу ирүүлэхийг мэдэгдье.

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
МЕНЕЖЕР

Д.АНХБАЯР
Ж.ЭНХЦООДОЛ

АУДИТЫН ТАЙЛАН БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР

П.МӨНХТУЯА

